



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/667/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Ахлах аудитор: Н.Баттогоо Утас: 325093 Цахим хаяг: battogoon@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-08-25 № 166
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН
ГАЗРЫН ДАРГА
Б.АМАРТҮВШИН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Боловсролын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Нийслэлийн Засаг даргын холбогдох захирамжийн хүрээнд нийт 9 төсөл, арга хэмжээний 35 багц, ажилд захиалагчийн хяналт тавьж, бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд тус төсөл, арга хэмжээний хүрээнд нийт 77 сургууль, цэцэрлэгт 1,762.6 сая төгрөгийн 2766 ширхэг сургалтын хэрэглэгдэхүүн, тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нийлүүлжээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нийслэл Улаанбаатар хотод 2023-2025 онуудад улс, нийслэл, дүүргийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 43 сургууль, 67 цэцэрлэг, 22 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 7 спорт заал нийт 139 боловсролын

1426050270

C:\Users\kharangia\Desktop\Бичвэр хэсэг 2026\2026-08-25\2026-08-25_08-25_0001.docx

байгууллагын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжүүлсэн байна. Үүнээс 2025 оны 7 сургууль, 19 цэцэрлэг, 7 бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга ашиглалтад орж сургуулийн суудлын тоог 6140-өөр, цэцэрлэгийн орны тоог 3700-аар тус тус нэмэгдүүлсэн байна.

“Сүүн дархлаа” зорилтот хүрээнд нийт 1,013.4 сая төгрөгийн төсвийг батлуулж, эцэг эх асран хамгаалагчдын дэмжлэгтэйгээр сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоолонд нэмэлтээр 7 хоногийн 2-3 өдөрт сүү, ааруулын шүүс зэргийг өгч байна.

Бусад асуудал

Тус газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 93.5 хувьтай хэрэгжиж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай хамтран ажиллах гүйцэтгэлийн төлөвлөгөө 91.2 хувь буюу бүрэн хангалттай хэрэгжүүлсэн гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Балансын үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	879,451,350.9	271,593,354.4
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		879,451,350.9	271,593,354.4
3121	Төгрөг		879,451,350.9	271,593,354.4
31211	Төрийн сангийн харилцах		879,451,350.9	271,593,354.4
33	АВЛАГА	5	5,395,265.8	123,750,000.0
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		5,395,265.8	-
3330	Татаас санхүүжилтийн авлага		-	123,750,000.0
33300	Татаас санхүүжилтийн авлага		-	123,750,000.0
35	БАРАА МАТЕРИАЛ	6	89,738,666.5	88,092,381.5
35300	Бэлэн бүтээгдэхүүн		-	54,424.0
354	Хангамжийн материал		89,738,666.5	88,037,957.5
35410	Бичиг хэргийн материал		3,798,585.0	2,284,600.0
35420	Аж ахуйн материал		24,927,081.5	24,740,357.5
35470	Бусад хангамжийн материал		61,013,000.0	61,013,000.0
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		<u>974,585,283.2</u>	<u>483,435,735.9</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	7,054,234,949.0	6,952,828,400.6
392	Биет хөрөнгө		246,312,906.8	237,454,713.6
39203	Авто-тээврийн хэрэгсэл		46,660,000.0	46,660,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл		(27,994,226.1)	(35,770,892.8)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		561,968,823.9	415,798,962.3
39206	Хуримтлагдсан элэгдэл		(361,581,560.0)	(235,885,858.4)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		127,453,000.7	80,978,441.0
39208	Хуримтлагдсан элэгдэл		(100,193,131.6)	(34,325,938.5)
393	Биет бус хөрөнгө		6,807,922,042.2	6,715,373,687.0
39301	Программ хангамж		22,495,000.0	-
39302	Хуримтлагдсан элэгдэл		(22,495,000.0)	-
39303	Бусад биет бус хөрөнгө		6,807,922,042.2	6,715,373,687.0
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		<u>7,054,234,949.0</u>	<u>6,952,828,400.6</u>
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		<u>8,028,820,232.2</u>	<u>7,436,264,136.5</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9	879,451,350.9	396,569,729.4
413	Өглөг		879,451,350.9	396,569,729.4
4136	Бусад өглөг		879,451,350.9	396,569,729.4
41361	Байгууллагад төлөх өглөг		879,451,350.9	396,569,729.4
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		<u>879,451,350.9</u>	<u>396,569,729.4</u>
51	Засгийн газрын хувь оролцоо		7,149,368,881.3	7,039,694,407.1
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		7,416,293,839.0	7,416,293,839.0

51101	Өмч:- төрийн		7,416,293,839.0	7,416,293,839.0
512	Хуримтлагдсан үр дүн		(266,924,957.6)	(376,599,431.9)
51210	Өмнөх үеийн үр дүн		(167,773,159.8)	(266,924,957.6)
51220	Тайлант үеийн үр дүн		(99,151,797.9)	(109,674,474.3)
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		7,149,368,881.3	7,039,694,407.1
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		8,028,820,232.2	7,436,264,136.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		23,835,511,144.1	26,350,536,562.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		20,465,445,500.0	23,443,070,700.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		20,465,445,500.0	23,443,070,700.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		3,370,065,644.1	2,907,465,862.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,191,282,144.1	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		174,373,500.0	2,903,715,862.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		4,410,000.0	3,750,000.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		12,576,967,648.0	2,164,008,387.0
120	Нийтлэг татварын бус орлого		12,576,967,648.0	2,164,008,387.0
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		12,576,967,648.0	2,164,008,387.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		12,434,744,270.0	2,051,861,100.0
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		87,197,378.0	112,147,287.0
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		55,026,000.0	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	36,412,478,792.1	28,514,544,949.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ		23,817,818,568.2	26,441,884,296.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,224,375,839.2	4,366,787,110.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,954,554,277.1	2,171,255,442.8
210101	Үндсэн цалин		1,110,130,619.6	1,145,440,505.2
210102	Нэмэгдэл		323,590,584.3	374,626,503.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт		341,660,348.1	454,725,298.8
210104	Урамшуулал		179,172,725.1	196,463,135.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		274,885,700.0	274,922,053.4
210201	Тэтгэврийн даатгал		205,210,500.0	187,541,355.3
210202	Тэтгэмжийн даатгал		17,418,800.0	21,994,633.5
210203	ҮОМШӨ-ний даатгал		8,709,400.0	11,181,723.5

210204	Ажилгүйдлийн даатгал		8,709,400.0	10,840,868.3
210205	Эрүүл мэндийн даатгал		34,837,600.0	43,363,472.8
2104	Хангамж, бараа материалын зардал		154,809,549.1	70,222,469.0
210401	Бичиг хэрэг		58,220,915.0	34,108,785.0
210402	Тээвэр, шатахуун		16,239,700.0	16,013,690.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		7,118,980.1	7,280,687.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		73,229,954.0	13,064,307.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		169,813,718.1	106,120,700.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		164,312,618.1	100,685,000.0
210803	Даатгалын үйлчилгээ		89,100.0	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		22,000.0	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		590,000.0	1,358,000.0
210807	Газрын төлбөр		4,750,000.0	4,015,000.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		50,000.0	62,700.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,670,312,595.0	1,744,266,445.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		2,592,830,657.0	1,637,825,836.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		9,820,001.0	23,360,800.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		67,661,937.0	83,079,809.0
212	ТАТААС		517,908,601.0	1,064,577,362.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас		517,908,601.0	1,064,577,362.0
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас		517,908,601.0	1,064,577,362.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		18,075,534,128.1	21,010,274,824.6
2132	Бусад урсгал шилжүүлэг		17,787,105,010.0	20,436,559,944.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		17,105,923,610.0	19,915,129,944.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		674,586,000.0	521,430,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		6,595,400.0	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		288,429,118.1	573,714,880.6
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		288,429,118.1	573,714,880.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		51,921,497.0	-
2200	Дотоод эх үүсвэрээр		51,921,497.0	-
220001	Барилга байгууламж		51,921,497.0	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	23,869,740,065.2	26,441,884,296.8
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		12,542,738,726.9	2,072,660,652.2
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		12,641,890,524.7	2,182,335,126.5
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		207,146,254.7	130,474,026.5
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		12,434,744,270.0	2,051,861,100.0
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		(12,641,890,524.7)	(2,182,335,126.5)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		(99,151,797.8)	(109,674,474.3)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,835,511,144.1	26,350,536,562.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	20,465,445,500.0	23,443,070,700.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	20,465,445,500.0	23,443,070,700.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,370,065,644.1	2,907,465,862.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,191,282,144.1	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	174,373,500.0	2,903,715,862.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,410,000.0	3,750,000.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,149,779,961.0	836,876,708.0
120	Нийтлэг татварын бус орлого	3,149,779,961.0	836,876,708.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,149,779,961.0	836,876,708.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,149,779,961.0	836,876,708.0
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	26,985,291,105.1	27,187,413,270.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,751,997,444.1	26,350,536,562.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,153,834,715.0	4,275,684,375.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,959,949,542.9	2,165,860,177.0
210101	Үндсэн цалин	1,115,525,885.4	1,140,045,239.4
210102	Нэмэгдэл	323,590,584.3	374,626,503.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	341,660,348.1	454,725,298.8
210104	Урамшуулал	179,172,725.1	196,463,135.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	274,885,700.0	274,922,053.4
210201	Тэтгэврийн даатгал	205,210,500.0	187,541,355.3
210202	Тэтгэмжийн даатгал	17,418,800.0	21,994,633.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,709,400.0	11,181,723.5
210204	Ажилгүйдлийн даатгал	8,709,400.0	10,840,868.3
210205	Эрүүл мэндийн даатгал	34,837,600.0	43,363,472.8
2104	Хангамж, бараа материалын зардал	31,585,380.1	36,078,811.0
210401	Бичиг хэрэг	7,555,000.0	9,490,900.0
210402	Тээвэр, шатахуун	10,034,700.0	13,300,090.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,118,980.1	6,757,912.0
210404	Ном, хэвлэл	-	600,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,876,700.0	5,929,909.0
2105	Нормативд зардал	-	110,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	110,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,884,000.0	408,650.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,749,000.0	-
210602	Тавилга	135,000.0	-
210604	Урсгал засвар	-	408,650.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	214,368,862.1	119,214,800.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	206,357,502.1	109,228,800.0
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.0	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.0	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,690,000.0	3,866,000.0
210807	Газрын төлбөр	4,750,000.0	4,015,000.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	460,260.0	2,105,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,661,161,230.0	1,679,089,884.0

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,634,457,640.0	1,640,932,584.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,703,590.0	38,157,300.0
212	ТАТААС	517,908,601.0	1,064,577,362.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	517,908,601.0	1,064,577,362.0
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	517,908,601.0	1,064,577,362.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,080,254,128.1	21,010,274,824.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,791,825,010.0	20,436,559,944.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,105,923,610.0	19,915,129,944.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	674,586,000.0	521,430,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,315,400.0	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	288,429,118.1	573,714,880.6
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	288,429,118.1	573,714,880.6
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	23,751,997,444.1	26,350,536,562.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,233,293,661.0	836,876,708.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,092,844,307.0	1,444,734,704.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,092,844,307.0	1,444,734,704.5
2200	Дотоод эх үүсвэрээр	3,092,844,307.0	1,444,734,704.5
220001	Барилга байгууламж	451,449,000.0	730,973,644.0
222001	Тоног төхөөрөмж	2,575,720,607.0	598,786,060.5
223001	Бусад хөрөнгө	35,000,000.0	114,975,000.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	30,674,700.0	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(3,092,844,307.0)	(1,444,734,704.5)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	140,449,354.0	(607,857,996.5)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	739,001,996.9	879,451,350.9
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	879,451,350.9	271,593,354.4

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	нийт дүн
1	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,416,293,839.0	-	(167,773,159.8)	7,248,520,679.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,416,293,839.0	-	(167,773,159.8)	7,248,520,679.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	(99,151,797.9)	(99,151,797.9)
8	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,416,293,839.0	-	(266,924,957.6)	7,149,368,881.3
9	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,416,293,839.0	-	(266,924,957.6)	7,149,368,881.3
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,416,293,839.0	-	(266,924,957.6)	7,149,368,881.3
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,бууралт	-	-	-	-
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
16	Тайлант үеийн үр дүн	-	-	(109,674,474.3)	(109,674,474.3)
17	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,416,293,839.0	-	(376,559,431.9)	7,039,694,407.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,443,070,000.0	22,993,105,819.4	449,964,180.6	98.1
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23,443,070,000.0	22,993,105,819.4	449,964,180.6	98.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	23,443,070,000.0	22,993,105,819.4	449,964,180.6	98.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,445,069,000.0	22,993,105,819.4	451,963,180.6	98.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,748,572,400.0	2,556,545,875.4	192,026,524.6	93.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,260,227,000.0	2,165,860,177.0	94,366,823.0	95.8
210101	Үндсэн цалин	1,166,488,100.0	1,140,045,239.4	26,442,860.6	97.7
210102	Нэмэгдэл	573,780,300.0	374,626,503.6	199,153,796.4	65.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	401,621,200.0	454,725,298.8	(53,104,098.8)	113.2
210104	Урамшуулал	118,337,400.0	196,463,135.2	(78,125,735.2)	166.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	301,403,000.0	274,922,053.4	26,480,946.7	91.2
210201	Тэтгэврийн даатгал	204,959,300.0	187,541,355.3	17,417,944.7	91.5
210202	Тэтгэмжийн даатгал	24,108,000.0	21,994,633.5	2,113,366.6	91.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,065,800.0	11,181,723.5	884,076.5	92.7
210204	Ажилгүйдлийн даатгал	12,053,900.0	10,840,868.3	1,213,031.7	89.9
210205	Эрүүл мэндийн даатгал	48,216,000.0	43,363,472.8	4,852,527.2	89.9
2104	Хангамж, бараа материалын зардал	40,868,400.0	32,349,211.0	8,519,189.0	79.2
210401	Бичиг хэрэг	7,237,600.0	9,490,900.0	(2,253,300.0)	131.1
210402	Тээвэр, шатахуун	9,238,400.0	9,570,490.0	(332,090.0)	103.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,919,000.0	6,757,912.0	6,161,088.0	52.3
210404	Ном, хэвлэл	600,000.0	600,000.0	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,871,700.0	-	3,871,700.0	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,001,700.0	5,929,909.0	1,071,791.0	84.7
2105	Нормативд зардал	110,000.0	110,000.0	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	110,000.0	110,000.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,775,000.0	408,650.0	8,366,350.0	4.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-	-	-
210602	Тавилга	-	-	-	-
210604	Урсгал засвар	8,775,000.0	408,650.0	8,366,350.0	4.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,773,600.0	29,714,800.0	6,058,800.0	83.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,729,800.0	19,728,800.0	1,000.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	-	-	-	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	-	-	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,989,100.0	3,866,000.0	3,123,100.0	55.3
210807	Газрын төлбөр	4,015,000.0	4,015,000.0	-	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,039,700.0	2,105,000.0	2,934,700.0	41.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	101,415,400.0	53,180,984.0	48,234,416.0	52.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,024,400.0	15,023,684.0	716.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	86,391,000.0	38,157,300.0	48,233,700.0	44.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,696,496,600.0	20,436,559,944.0	259,936,656.0	98.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,696,496,600.0	20,436,559,944.0	259,936,656.0	98.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,164,080,200.0	19,915,129,944.0	248,950,256.0	98.8
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	532,416,400.0	521,430,000.0	10,986,400.0	97.9

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,445,069,000.0	22,993,105,819.4	451,963,180.6	98.1
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	879,451,350.9	(879,451,350.9)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	271,593,354.4	(271,593,354.4)	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	69.0	63.0	6.0	91.3
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	61.0	55.0	6.0	90.2
620003	Үйлчлэх ажилтан	7.0	7.0	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	62.0	56.0	6.0	90.3
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	3.0	3.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,907,465,862.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,907,465,862.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,903,715,862.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,750,000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,783,715,862.0
210402	Тээвэр, шатахуун	3,729,600.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	89,500,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,625,908,900.0
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	1,064,577,362.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,783,715,862.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	123,750,000.0
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	123,750,000.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 26,458.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 307,476.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 11,205.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт хүргүүлж, 296,271.6 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 307,476.8 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Дөрөв. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалт тай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Татварын тайлангаар цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан 10,316.6 мянган төгрөгийн татварыг дутуу, суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан 12,683.4 мянган төгрөгийг албан татварыг илүү тайлагнасан байна.	1	23,000.0	-	-	1	23,000.0	1	23,000.0	-	-	-	-
2	Бараа материалын дансанд үндсэн хөрөнгө бүртгэсэн байна.	1	3,458.7	-	-	1	3,458.7	1	3,458.7	-	-	-	-
	Дүн	2	26,458.7	-	-	2	26,458.7	2	26,458.7	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлээгүй НЗД-ын захирамжаар нийт 4 арга хэмжээний зардалд 80,373.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	80,373.0	-	-	-	-	1	80,373.0	-	-	-	-

Нийслэлийн Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2	Хөрөнгө оруулалтын 2022-2023 онуудын хийгдсэн ажлуудын ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлд заасан барьцааны хугацаа дууссан байтал гүйцэтгэгч ААНБ-уудад нийт 11,205.2 мянган төгрөгийг буцаан олгоогүй, ашиглагч байгууллагууд барьцаа олгохыг зөвшөөрсөн албан бичиг ирүүлээгүй, төсөвт төвлөрүүлээгүй байна.	1	11,205.2	1	11,205.2	-	-	-	-	-	-	-	-
3	Санхүүгийн тайланд үнэлж бүртгэсэн газруудыг цахим бүртгэлтэй тулган үзэхэд кадастрын зураг, нэгж талбайн дугаар нь баталгаажуулаагүй 2 объектын 14,001м2 хэмжээтэй, 161,906.0 мянган төгрөгийн газар байна.	1	161,906.0	-	-	-	-	1	161,906.0	-	-	-	-
4	Бараа материал дансанд хөдөлгөөн ороогүй, ашиглагдахгүй хөрөнгүүд байна.	1	51,600.0	-	-	-	-	1	51,600.0	-	-	-	-
5	Хөтөлбөр, арга хэмжээний зардлын төсөвт хоол, цайны зардал баталж, зарцуулж байгаа нь үрэлгэн зардал гаргасан байна.	1	2,392.6					1	2,392.6				
Дүн		5	307,476.8	1	11,205.2	-	-	5	296,271.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад орлого, зарлагын таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 55 гүйлгээ, зардлын 129 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 2 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	-	-	-	-	-	1	-
Дүн		-	-	-	-	-	-	-	-



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 15/А0260171

Улаанбаатар хот

НТАГ-2026/667/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлд заасан барьцаа хөрөнгө болох 11,205,200.00 (арван нэгэн сая хоёр зуун таван мянга хоёр зуун) төгрөгийг хугацаа дууссан боловч орон нутгийн төсвийн орлогын ерөнхий дансанд төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;", Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаадагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8 "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Хугацаа дууссан барьцаан хөрөнгийн 11,205,200.00 (арван нэгэн сая хоёр зуун таван мянга хоёр зуун) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ. хүү торгуулийн орлогын MN440090 100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

1428790078

2.Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн боловсролын газрын дарга Б.Амартүвшин, ахлах нягтлан бодогч, Д.Наранхүү нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОНТ:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Г.НАНДИНЖАРГАЛ
АХЛАХ АУДИТОР  Н.БАТТОГОО



¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

